

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/118/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.umnugovi@audit.gov.mn Өмнөговь аймаг 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 88034203 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 88025452 Цахим хаяг: jargale@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

2022.02.16 № 36

танай _____ -ны № _____ -т

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА
Н.МИШИГДОРЖ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

018026042

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д. ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	380,4	509,2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,870,7	5,672,3
	Нийт хөрөнгийн дүн	6,251,1	6,181,5
	Нийт өр төлбөрийн дүн	0	59,545.172.85
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,251,1	6,122,0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,251,1	6,181,5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,229,9	4,973,6
	Үйл ажиллагааны зардлын дүн	4,080,6	5,102,7
	Үйл ажиллагааны үр дүн	149,3	-129,1
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	149,3	-129,1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	659,0	659,0
	Тайлант оны үр дүн	149,3	-129,1
	Эцсийн үлдэгдэл	6,251,1	6,122,0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,371,0	4,227,7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,351,8	4,187,3
	Үйл ажиллагааны ЦМГ	19,1	40,3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0	0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,990,2	2,988,8
	Урсгал зардал	2,990,2	2,988,8
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,990,2	2,988,8
	Улсын төсвөөс санхүүжих	2,922,7	2,911,5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	67,4	77,3

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Цагдаагийн газар “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах”, “Үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангана”-аар зорилгоо тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, удирдлагын манлайллыг дээшлүүлэх чиглэлээр сургалт явуулах
- Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлуулж, удирдах албан тушаалтнуудыг Төрийн албаны тухай хуульд заасан шалгуур, шаардлагын дагуу томилж тогтвор суурьшилтай ажиллуулах
- Алба хаагчдын сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулж, гэмт хэрэг, сахилгын зөрчил үйлдсэн болон холбогдсон алба хаагчийн тоо өмнөх оноос бууруулах
- Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ялангуяа тухайн албан тушаалд нь мэргэшүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах
- Алба хаагчдад багаар ажиллах ур чадварыг эзэмшүүлэх
- Алба хаагчдын аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион байгуулж, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах.
- Дэвшилтэд техник, технологи /дундаж хурдны камер, дугаар илрүүлэгч камер, /-ыг нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглах.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол улсын Засгийн газрын 2021 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага нь бичиг хэргийн зардлаас 0.2 сая, шуудан холбооны зардлаас 0.6 сая, урсгал засварын зардлаас 6.7 сая төгрөг нийт 7.4 сая төгрөгийг үндсэн хөрөнгө худалдан авсан,
- Тайлант онд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 0.1 сая, хоолны зардлаас 0.1 сая, цэвэр бохир усны зардлаас 0.2 сая, тээврийн хэрэгслийн оношилгооны зардлаас 0.7 сая төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөговь аймгийн Цагдаагийн газар тайлант хугацаанд оруулбал зохих орлогын 70 гүйлгээ буюу 4.0 сая төгрөгийн, зарлагын 26 буюу 254.3 сая төгрөгийн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-г мөрдөж ажиллаагүй төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 8.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 0.02 сая төгрөгийн алдааг залруулж, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Ахмадын сан байгуулах журам"-тай холбоотой 2 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Тус байгууллага нь бичиг хэргийн зардлаас 0.2 сая, шуудан холбооны зардлаас 0.5 сая, урсгал засварын зардлаас 6.7 сая төгрөг нийт 7.4 сая төгрөгийг үндсэн хөрөнгө худалдан авах болон үйлчилгээний төлбөрт зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах

2.Илрүүлэлт:

Тайлант онд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 0.1 сая, хоолны зардлаас 0.1 сая, цэвэр бохир усны зардлаас 0.1 сая, тээврийн хэрэгслийн оношилгооны зардлаас 0.7 сая төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Ахмадын сан байгуулах журам"-ыг хэрэгжүүлэн ажиллах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

[illegible]